

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

МОНГОЛ УЛСЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖИЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТ

У.Тианбао /Wu Tianbao/*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант (ӨМӨЗО)

Түлхүүр үг: эрэн сурвалжлах мэдээлэл, “боомт сахигч”, мэргэжил, өөрийн өртөг (cost), тулгын чулуу, сэтгүүл зүйн нийгмийн үүрэг, мэдээллийн урсгал.

Хүмүүс нийгэмд нөлөөлөхдөө мэдээллийн тусламжтайгаар хоорондоо харилцаж санал бодлоо, туршлагаа харилцан солилцож, мэдээлэл нийгмийн үйл явцад зөв байраа эзэлж, зөв чиг баримжаа олж авахад тусалдаг. Нийгмийн мэдээллийг хүмүүс хоорондоо харилцах мэдээлэл, ХМ-ийн тусгай хэрэгслээр цацаж байгаа мэдээлэл хэмээн ангилж болно. Түүний хоёр дахь ангилал нь сэтгүүл зүйн мэдээлэлд багтах бөгөөд тусгай субъект нийгмийн мэдээллийг цуглуулж боловсруулаад, эргээд нийгмийн хэрэгцээнд зориулан түгээж байгаагаараа онцлогтой юм. Ерөнхийдөө сэтгүүл зүйн нийгмийн үүрэг нь нийгэм хэмээх их системд үйлчлэх мэдээллийн урсгалыг хангах явдал юм. Сэтгүүл зүйн бүх бүтээгдэхүүн мэдээлэл агуулах бөгөөд “амьдралын тодорхой хэсгийн баримт, үйл явдалд тулгуурлан мэдээллийг нийгмийн тодорхой хэсэгт зориулан туйлын шуурхай хүргэдэг үйл ажиллагааг сэтгүүл зүй”¹ хэмээн сэтгүүл зүйн онолчид тодорхойлжээ. Мөн “Сэтгүүл

зүйн тайлбар толь бичиг”-т “Сэтгүүл зүй бол цаг үеийн мэдээллийг цуглуулж боловсруулан олон түмний харилцааны сувгуудаар тогтмол түгээж байдаг нийгмийн үйл ажиллагааны нэг төрөл бөгөөд олон түмэнд ухуулга суртал нэвтрүүлэг явуулах нэг хэлбэр”² хэмээжээ. Энэ утгаараа сэтгүүл зүй нийгмийн хөгжилд тустай бүтээлч үйл ажиллагаа бөгөөд мэдээллийг боловсруулах ажлыг амжилттай биелүүлэх, түүнийг бүрэн хөгжүүлэх үндэс суурь юм. Энд Монгол Улсын сэтгүүл зүйн мэдээллийн нэг чухал бүрэлдэхүүн болох эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах ажлыг “боомт сахигч”, “мэргэжил”, “өөрийн өртөг” зэрэг ойлголтын хүрээнд шинжилгээ хийлээ.

Нэг. Эрэн сурвалжлах мэдээллийн боловсруулалт ба “боомт сахигч”

“Боомт сахигч” хэмээх онолыг Америкийн мэдээлэл зүйн дөрвөн гол онолчдын нэг К.Левин 1947 онд анх гаргаж иржээ. “Боомт сахигч” гэдэг бол ОНМХ-ээр ямар мэдээг дамжуулж болох, хэзээ мэдээлэх, хэрхэн мэдээлэхийг тогтоодог хүн буюу байгууллага юм². 1950 онд мэдээлэл зүйн судлаач Д.Уайт энэ ойлголтыг сэтгүүл зүйд анх хэрэглэж, мэдээлэл сонгох явцын “боомт сахих” загварыг боловсруулж,

сэтгүүл зүйн мэдээлэлд зохиогч өөрийн магадлалаар эх бичвэрийг хэрэглэх эсэхийг тогтоох ажиллагаа хэмээн үзжээ. Үүнийг дагалдан олон судалгааны өгүүлэл, ном, сурах бичигт мэдээлэл боловсруулах “боомт сахигч”-ийн тухай судалгаа олширч, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага бүр “боомт сахигч” мөн гэсэн дүгнэлт хийсэн байна. Эдгээр “боомт сахигч” нь ямар сэдэв сонгогдох болон хаягдах, ямар эх сурвалж нь хэрэглэгдэх хийгээд

хэрэглэгдэхгүй, цаашид мэдээллийн гарчиг, зохиомж, сурвалжлах арга барил зэрэг мэдээлэл боловсруулах бүхий л үйл ажиллагаанд үйлчилж, өөр өөрийн боомтоо сахих байна.

Эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах үйл явц гол төлөв хоёр хэлбэрээр явагддаг байна. Нэг нь дээрээс доошоо тогтсон сэдэв, нөгөө нь доороос дээшээ чиглэсэн сэдэв юм. Энэ хоёр төрлийн дунд “боомт сахигч”-ийн дүр нь бүрмөсөн нэгдсэн биш, өөр өөрийн онцлогтой, хоорондоо уялдаа холбоотой байдаг.

Эхлээд дээрээс доошоо чиглэсэн сэдвийн талаар ярья. Энэ төрлийн эрэн сурвалжлах мэдээллийн ихэнх нь ХМ-ийн байгууллагаас тогтоосон сэдэв байхын зэрэгцээ улс төр, нийгмийн онцлох сэдэв бөгөөд ердөө тайлбарлах шинжтэй эерэг талын мэдээлэл байдаг. Энэ төрлийн эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах явцад үйл явдлын тухай талбарт очсон сэтгүүлчийн

“боомт сахигч”-ийн үүрэг нь харьцангуй бага байх бөгөөд тэд зөвхөн гол сэдвийн шаардлагаар мэдээллийн эх материалыг цуглуулах ажлыг хариуцаж, идэвхтэй мэдээллийн бүтэц хийгээд үг яриаг зохион байгуулах чадвараа сайтар хэрэглэж, редакцийн шаардлагад нийцсэн хангалттай эх материал бэлтгэхийг чухалчилдаг. Энэ төрлийн эрэн сурвалжлах мэдээлэлд сэтгүүлчийн “боомт сахих” шаардлага харьцангуй бага байдаг. Учир нь мэдээллийн агуулга доторх үлдээж, хаях баримжаа нь урьдчилан тогтоогдсон байж, сэтгүүлч зөвхөн тогтсон цар хүрээнд ажиллагаа өрнүүлж, агуулгыг бичиж, бүтцийг ашиглаж, нийтлэлийн бодлогод харшлахгүй байхыг анхаардаг. Энэ төрлийн мэдээллийн чухал “боомт сахигч” бол



Эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах үйл явц гол төлөв хоёр хэлбэрээр явагддаг байна. Нэг нь дээрээс доошоо тогтсон сэдэв, нөгөө нь доороос дээшээ чиглэсэн сэдэв юм. Энэ хоёр төрлийн дунд “боомт сахигч”-ийн дүр нь бүрмөсөн нэгдсэн биш, өөр өөрийн онцлогтой, хоорондоо уялдаа холбоотой байдаг



ХМХ-ийн дээд давхаргын шийдвэр тогтоох гаргах дарга нар байж, тэд мэдээллийн гол сэдэв, агуулга, сурвалжлах ажиллагааны арга барил, цаашид сонин сэтгүүлийн нүүрийн дизайн, үсгийн тоо, телевизийн сувгийн нэвтрүүлэх зураг дүрс, цаг хугацаа зэргийг тогтооно. Энд сэтгүүлч мэдээллийн гүйцэтгэгчийн дүрд тоглож байгаа бөгөөд идэвх санаачилгатай эрхийг эзэмшиж байгаа “боомт сахигч” биш байдаг.

Доороос дээш уудлан хайх эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах нь дээрхээс өөр юм. Энэ төрлийн эрэн сурвалжлах нь мөрдөн судлах мэдээллээр их байж, сөрөг үзэгдлийг илчилж,

нийгмийн асуудал зэрэг том сэдвээр голлодог мэдээлэл мөн. Эхлээд мэдээллийн сэдэв сонголт нь сэтгүүлчийн хувьд өөрөө шилэн сонгох “боомт сахих”-ийг тогтоож, мэдээлэгч болон сэтгүүлчийн өөрөө цуглуулсан мэдээ ч хамаагүй, сэтгүүлчид мэдээлэх үнэ өртөг харагдвал, боловсруулах явцад орох боломжтой. Ингээд редакци “боомт сахигч”-ийн боломжийг ашигладаг. Тэд сэтгүүлчтэй дахин ярилцаж, сонгосон сэдвийнхээ бодитой эсэхийг баталж, цаашид сэтгүүлчээс нарийн нягт сурвалжлах төлөвлөгөө гаргахыг шаардана. Редакцийн энэ “боомт”-ыг давсны дараа, сонгосон сэдвийг харъяалагдах хэлтсийн хурал дээр бусад сонгосон сэдвийн хамт нээлттэй хэлэлцэж, харьцуулах, мэдээлэх өртгийг нь урьдчилан тооцоолж, сэтгүүлч бодитой сурвалжлан бичих ажлаа өрнүүлнэ. Энэ бол мэдээллийн сэдэв сонголт дахь “боомт сахих” үйл явц, мөн энэ төрлийн эрэн сурвалжлах мэдээллийн “боомт сахих” ажлын эхний шат мөн.

Дараагийн шатанд сэтгүүлчийн “боомт сахигч”-ийн дүр нь гүйцэд харагдана. Тэд нар сурвалжлах этгээдээ өөрөө тогтоож, бичих асуудлыг олж, түүний хариултыг олохыг хичээдэг. Энэ явцад сэтгүүлч редакцтай нягт холбоотой ажиллаж, сурвалжлах, бичих явцад байнга санал солилцож байдаг бөгөөд заримдаа санал зөрчилдөх, маргах явдал ч гардаг. Сэтгүүлч энэ үед зөвхөн мэдээллийн гүйцэтгэгч биш, харин “эх бичвэрийн алдааг өөрөө хариуцах” өөрийн мэдэлтэй, биеэ даасан сэтгүүлч болж, тэд сэтгүүл зүй дэх нэр хүндээ хамгаалахыг хичээдэг. Ерөнхийдөө энэ төрлийн эрэн сурвалжлах ажиллагаа явуулж байгаа сэтгүүлчид “боомт сахигч”-ийн чадавхийг мэдээллийн

дундаа илрүүлж, зарим сэтгүүлч түүний эх бичвэрийг засахыг хориглодог.

Мэдээллийн эх бичвэр сэтгүүлчийн гараас гарч редакцид өгсний дараа гурав дахь шатны “боомт сахих” ажил эхэлдэг. Редакци эх бичвэрийн зарим хэсгийг хасах эрхтэй, гэхдээ хасах шалтгаан нь ямар ч байж болно. Заримдаа сэтгүүлчээр баримт мэдээллийг нөхүүлэх эсвэл дахин ярилцлага авахыг шаарддаг. Эх бичвэр редакцийн боомтыг давсны дараа ХМХ-ийн удирдлагын шийдвэрээр эцсийн боомтыг сахина. Энэ шатны нөлөөлөх элемент нь эх бичвэрийг хянан найруулах түвшин, мэдээллийн үнэ цэнээс бус, харин мэдээллийн үр нөлөөнөөс шалтгаалдаг. Энэ мэдээлэл нь удирдах байгууллагын хязгаарлалт, эсвэл зарим ашиг тусын этгээд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх эсэхийг шалгаж, эдгээр үр нөлөөний аль нэгийг хөндөхөд хүрвэл эцсийн “боомт сахигч” (ХМХ-ийн шийдвэр гаргах этгээд)-аас энэ мэдээллийг түр хойшлуулах эсвэл шууд авч хаях магадлалтай юм.

Эдгээр “боомт сахигч” нь хэдийгээр эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах шаардлагыг чанд сахиж, шилдэг мэдээлэл гарч ирэхэд тустай боловч, өнөөгийн Монгол Улсын сэтгүүл зүйгээс харахад энэ тусламж нь хүч сул бөгөөд сөрөг нөлөө нь харьцангуй их болжээ. Энэ байдал нь сэтгүүлч хийгээд хэвлэл мэдээллийн байгууллага ашиг орлогыг бодоод төр засаг, бизнесийн байгууллага болон тухайн асуудалтай холбоотой хувь хүнтэй “харьцаа” үүсгэж, түүнийг хамгаалахын тулд шударга мэдээлэл хийхийг “боомт сахих” баримжаа болгосны үр дагавар юм.

Хоёр. Эрэн сурвалжлах мэдээллийн боловсруулалт ба “мэргэжил”

Сэтгүүл зүйн мэдээлэл түгээх чадавхийн үүднээс эрэн сурвалжлах мэдээллийг харьцуулж үзвэл нийгэмд оролцох, нөлөөлөх чадвар нь бусад төрлийн мэдээллээс их байдаг нь мэдээж юм. Тийм учраас эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах нь өөр мэдээллийг боловсруулахаас “мэргэжил”-ийн өндөр ур чадвар шаарддагаараа онцлогтой. Энэ бол зөвхөн сэтгүүлчийн хувийн мэргэжлийн түвшнээс гадна хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн түвшинд ч хамаатай юм. Гэтэл өнөөгийн Монгол Улсын сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн талд асуудал оршиж, шилдэг эрэн сурвалжлах бүтээл гарахад саад учруулж, цаашид бүхий л сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөрөг нөлөө үзүүлж байгаа нь ажиглагддаг.

Нэгд, улс төрийн хувьд биеэ даасан, эрх мэдэлт, хараат бус ХМХ-ийг хөгжүүлэхэд бэрхшээл их; хоёрт, эдийн засгийн бие даасан байдал, эрх чөлөөг хангахад саад бэрхшээл их; гуравт, ХМХ-ийн дүрмийн мэргэжсэн түвшин доогуур; дөрөвт, ХМХ-ийн зарчим ойлголт тодорхойгүй байна. Ерөнхийд нь авч үзвэл Монгол Улсын ХМХ-ийн эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах ойлголт хэтэрхий төвийг сахисан, олон “хориотой бүс” оршиж байгаа нь ХМХ-ийн мэргэжлийн түвшнийг бууруулж, хөгжиж дэвжихэд саад бэрхшээл учруулж байна. Тиймээс Монгол Улсын ХМХ-ийн байгууллагуудын мэргэжлийн түвшин бүхэлдээ өндөр биш байгаа нь эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах, сэтгүүлчийн мэргэжлийн түвшнийг дээшлүүлэхэд сөрөг орчныг бий болгон, тэдний мэргэжлийг дээшлүү-

лэхэд саад учруулах гадаад нөлөөлөх хүчин зүйл болжээ.

Мэргэжил гэсэн ойлголт латины *professio* гэсэн үгнээс эхтэй бөгөөд *profiteor* буюу “өөрийнхөө ажлыг зарлах, мэдүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, лекц унших, хичээл заах, санал болгох, үзүүлэх” гэсэн утгатай үйл үгээс гаралтай ажээ. Профессор гэдэг үг ч энэ үгнээс гарчээ. Мэргэжил гэдэг бол тусгай бэлтгэл, ажил туршлагын үр дүнд олж авсан онолын цогц мэдлэг, үйлдлийн дадлага эзэмшсэн хүмүүсийн хөдөлмөрийн үйл ажиллагааны тодорхой төрлийг илэрхийлдэг³ юм. Сэтгүүлчийн мэргэжлийн ерөнхий шинжийг шуурхай мэдээлэх, танин мэдүүлэх, нийгмийн чиг баримжаа олгох, зугаацуулах, зар сурталчилгаа хүргэх зэрэг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн бүтээлч үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Сэтгүүлч үйл ажиллагаа явуулах явцад ёс зүйгээр оюун тархи цэнэглэж, ур чадвараа гар хөлөө болгож шилдэг эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулахдаа амьд, бүтээлчээр ажиллах шаардлагатай. Ёс зүй бол хуулиар баталгаажуулах боломжгүй, хувь хүний бие сэтгэлийн зүйл мөн. Монгол Улсад Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим гэж тунхаг гаргаж, сэтгүүлчдийг энэ зарчмын дагуу ажиллахыг шаардаж байна. Гэтэл сэтгүүлчийн ёс зүйн алдаатай эрэн сурвалжлах нийтлэл бас ажиглагдаж байна. Тухайлбал, мэдээлэлд сэтгүүлчид өөрийнхөө үзэл бодлыг оруулах, далд сурталчилгааг нэмэх, буруу гарчиг, худал зураг хэрэглэх хийгээд баталгаажуулаагүй мэдээ, таамаг цуу яриа их хэрэглэх шинжтэй алдаа цөөнгүй байна. Зарим нь эрэн сурвалжлах нэрийн доор олсон баримтынхаа дагуу дуулиан шуугиан дэгдээж, нэг удаагийн

мэдээлэл хийж, хэдийгээр албан тушаалтан, баячуудын хууль бус ёс суртахуунгүй үйл ажиллагааг нийгэмд таниулж байгаа ч, тухайн мэдээлэл ямар үр дүнд хүрснийг эргэн мэдээлэхгүй орхигдуулж байгаа нь сэтгүүлч зүгээр л дуулиан шуугиан дэгдээж, хүлээн авагчийн тоог нэмж, цаашид өөрийгөө олонд таниулах хувийн хүсэл мэт харагдуулж байна. Мэдээлэл боловсруулах явцад ёс зүйн алдаа гардаг шалтгаан нь сэтгүүлч болон ХМХ-ийн авилгад үйлчлэх, ашиг олохын төлөө, богино хугацаанд олны танил болох нэр алдрын төлөө хөөцөлдсөнөөс болж байна. Зарим ХМХ-д үзүүлж буй дарамт ч ёс зүйн алдаа гарах шалтгаан болдог. Зарим этгээд сэтгүүлчид болон ХМ-ийн байгууллагад авилга өгч хувьдаа үйлчлүүлж чадахгүй бол ажил төрөл, гэр бүлийн байдалд зориуд саад учруулж, цаашлаад амийг нь хөнөөх хэргийг ч хийдэг учраас сүрдүүлэгт автагдсан сэтгүүлч, ХМ-ийн байгууллага нь тэд нарын санааг дагаж, ёс зүйн алдаа гаргах тохиолдол ч бас байдаг юм.

Ур чадвар бол бүтээлч үйл ажиллагааны аль ч салбар, хүрээнд байдаг нэлээд өргөн агуулга бүхий нийтлэг ойлголт бөгөөд аливаа зүйлийг тодорхой шаардлагын түвшинд урлан бүтээх чадварыг маш энгийнээр ур чадвар гэж ойлгож болно. Сэтгүүлчийн ур чадварыг баримтыг сонгон цуглуулах, олсон баримтаа тайлбарлах, ургуулан бодох авьяас, уг үзэгдлийн дотоод мөн чанарт нэвтрэн орох, таамаглах, магадлах, учир шалтгааныг тодруулах чадвар гэж ойлгож болно.

Эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах ажлын хүрээнд оршиж байгаа ур чадварын асуудал нь мэдээ

баримтыг боловсруулах явцад нэг баримтыг нөгөө баримтаар баталгаажуулах нь дутмаг, мэдээг (сэдэв, агуулга) шилж сонгох нь шинжлэх ухаанч биш хоёр талд төвлөрч байна.

Эх сурвалжаас олсон мэдээгээ сайтар шилэн сонгож, сэдвээ зөв тодорхойлох, агуулгаа оновчтой илэрхийлэх нь нийтлэлийн үр нөлөөний гол асуудал юм. Гэхдээ сэтгүүлчид эрэн сурвалжлах мэдээллийн сэдэв ямар байдгийг мэдэхгүй байгаа нь том дутагдал юм. Сэтгүүлчид аль хэдийнэ олон нийтэд ил болсон сэдвийн хүрээнд эргэлдэж, өнгөрсөн үйл явдлыг эсвэл аливаа гэмт ажиллагаанаас сэрэмжлэхийг иргэдэд сануулах төдий байдаг нь түгээмэл. Ингэж сэдвээ буруу сонгосноос жинхэнэ эрэн сурвалжлах ёстой хууль бус ажиллагаа, хээл хахууль, авилга, албан тушаалтны хэрэг газар авах нь түгээмэл юм. Үүний хамт сэдвийн хүрээ явцуу, эх сурвалж нь дутмаг байна. Эдгээр сул тал нь мэдээллийн тэнцвэрт байдал алдагдах, аль нэг талыг барьж туйлшрах, эх сурвалжаас мэдээлэл олж авах арга барилд нөлөөлж байна. Нууц баримт олж авахын тулд эх сурвалжтай харилцахдаа арга барилын буруугаас болж эх сурвалжаа алдах, эрэл хайгуулаа зогсооход хүрч, олж авсан сэдэв, уулзаж учирсан эх сурвалж, цуглуулсан баримтынхаа хүрээнд мэдээлэл боловсруулж байгаа ч олон түмний анхаарлаас гадуур өнгөрч, ард түмний анхааралд хүрч, санаа бодолд нөлөөлөх хэмжээнд хүртэл боловсруулах чадвар нь сул байна.

Гурав. Эрэн сурвалжлах мэдээллийн боловсруулалт ба “өөрийн өртөг”

Эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах явцад мэдээллийн зар-

чим болон зах зээлийн зарчим хоёрын хооронд асар их зөрүү оршдог. “Зах зээлийн зарчмын онц чухалчилдаг гурван элемент бол: боловсруулах өөрийн өртөг, хүлээн авагчийн хэмжээ, хамаа бүхий ашиг тусын хүн, бодистой зөрчилдөх түвшин юм. Үүнтэй зохицолдон үүссэн мэдээллийн зарчим бол: мэдээлэл боловсруулах бол мөнгийг бууруулах, реклам өгөгчдөд ашигтай хүлээн авагчийг татах, хамаа бүхий ашиг тусын хүн бодистой зөрчилдөхийг хичээх”⁴ явдал юм. Америкийн судлаач, доктор МакМанус Жон 1994 онд хэвлэсэн “Market-driven Journalism” хэмээх бүтээлд зах зээлийн сонин мэдээний үйлс гэдэг ухагдахууныг дурдаж, зах зээлийн сонин мэдээний үйлс, хүлээн авагчийг цуглуулж, мэдээллээр хангахыг зорилго болгоогүй, харин рекламн бизнест худалдагджээ. Үүнд цөөн хэдэн тооны том компани ялагч болж, хүлээн авагч ялагдагч болсон байна”⁵ гэжээ. Үүнээс ХМХ-үүд зах зээлийн дүрэм, ашиг сонирхлын хуульд захирагдаж байдгийг харж болно. Зах зээлийн зарчмаар эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах нь хүлээн авагчийн хэмжээ болон хамаа бүхий ашиг тусын хүн бодисын зөрчилдөх түвшний талд үг хэлээ ололцож чадсан ч, боловсруулах өөрийн өртгийн талд буулт хийхгүй гэдэг нь тодорхой.

Мэдээллийн зарчим бол хүлээн авагчийн ойлгох сонирхлыг хангахын төлөө өөрийн өртөгт хязгаарлагдахгүйгээр мэдээлэл үйлдэж болно. Гэтэл өнөөгийн Монгол Улсын ХМХ дотор МҮОНТ-ээс бусад нь бүр хувь хүн, компани, бүлэглэлээс хөрөнгө оруулалт хийсэн учраас эдийн засгийн хувьд зах зээлд хандсан байлдах бодлого явуулж, ашиг орлого бол тэд нарын өөрсдийн эрүүл хөгжилтөө олох

баталгаа мөн гэсэн ойлголтыг харж болно. Зарим ХМ-ийн байгууллага нь ганц ашиг орлогын төлөө хөөцөлдөж байгаа үзэгдэл ч бий. Энэ нь мөн эл ХМХ-ийн зах зээлийн зарчимтай зохицож өөрийн оршин тогтнох хөгжилтөө олохоор чармайж байгаа үзэгдэл юм. Үүний улмаас эл ХМ-ийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлэг нь зах зээлийн зарчимтай зохицолдсон байхыг шаардана. Тиймээс эрэн сурвалжлах мэдээллийг боловсруулах өөрийн өртөгт олон талын нөлөөлөх хүчин үйлчилж, тэд хоорондоо уялдаа холбоотой байж өөрийн өртгийг будлиантай болгож, мэдээлэл боловсруулах ажлын тулгамдсан асуудлын нэг нь болжээ. Үүнээс үзвэл өнөөгийн Монгол Улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйд мэдээллийн боловсруулах өөрийн өртөгт хүний хүч, эх сурвалж эрж хайх, эрсдэл зэрэг гурван бүлэг нөлөөлөх хүчин үйлчилж байна.

Нэгд, эрэн сурвалжлах сэтгүүл зүйд хүний хүчний талын шаардлага энгийн сэтгүүлчээс улам өндөр байдаг. Монгол Улсад эрэн сурвалжлах нэвтрүүлгээр нэр цуутай “Eagle” телевизийн “Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн нийгэмлэг”-ийн хийсэн “Эрэн сурвалжлагч” нэвтрүүлэг нь тооны олон цөөнөөр биш, харин чанар хийгээд нөлөөлөх чадвараар үр өгөөжтэй, бүтээлч хандлагатай гэдгийг баталдаг. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүлч багагүй цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулан сурвалжилж, чанартай нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхийг хичээдэг. Тэд ердөө арав хоног, хагас сар цаашид хэдэн сарын цаг зарцуулж нэг эрэн сурвалжлах нэвтрүүлгийг бэлтгэдэг. Тухайлбал, нэрт сэтгүүлч Г.Жамъян гуай Монголын ардчилсан хувьсгалд оролцсон хүмүүсийн дотор хилс хэрэгт холбогдсон нөхдийн тухай 5 жил зарцуулж “Сод

хүмүүн” гэх эрэн сурвалжлах шинжтэй номоо хэвлүүлжээ. Ийм урт хугацаагаар мэдээлэл цуглуулахыг энгийн сэтгүүлч чадахгүй нь лавтай. Гэхдээ өнөөгийн Монгол Улсад ийм их хүч зарцуулдаг эрэн сурвалжлах сэтгүүлчдийг үнэлж, урамшуулах арга барил, тогтсон дүрэм журам бүрэн төгөлдөр биш, тусгайлан эрэн сурвалжлага хийж байгаа сэтгүүлчид найдвартай баталгааны тогтолцоог бүрэн хангаж чадахгүй байна. Энэхүү боловсруулах өөрийн өртөг өндөр, асар их хүч хөдөлмөр шаарддаг эрэн сурвалжлах сэтгүүл зүйд иж бүрэн үнэлгээ өгч баталгааны тогтолцоо байхгүй бол эрэн сурвалжлах сэтгүүлчийн хүч хөдөлмөр нь зарлагатайгаа тэнцүүгүй болно. Сэтгүүлчийн ажиллах хугацаа нь түүний зарцуулах хүний хүчинд шууд нөлөөлж байгаа учраас цаг хугацаа, хүч хөдөлмөр их шаардлагатай гэдэг нь тодорхой. Эрэн сурвалжлах сэтгүүлчийн цалин хөлс ч энгийн сэтгүүлчээс өндөр байх учиртай. Эрэн сурвалжлагч хүн хүчний өндөр шаардлага хангаж чадахгүй бол сэтгүүлчийн идэвх санаачлага, мэдээллийн чанарт шууд нөлөөлдөг. Энэ төрлийн асуудал бол эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах ажиллагаа явуулж байгаа ХМ-ийн байгууллага бүрт тулгардаг юм.

Хоёрт, эрэн сурвалжлах мэдээллийн эх сурвалжийг эрж хайх үйл ажиллагаа нь энгийн мэдээллээс хамаагүй хүнд. Сэтгүүлчийн уг чанар бол мэдээ цуглуулах болон түгээх юм. Эрэн сурвалжлах сэтгүүлчийн гол үүрэг бол тэдгээр нуугдаж байгаа болон зориуд нуун дарж байгаа мэдээг цуглуулж түгээхэд оршино. Тиймээс эрэн сурвалжлах мэдээллийн эх сурвалж цөөн, бас ашиг тусын хүнд

зориуд харшилах хэрэг үүсэх тул амархан олох боломжгүй байдаг.

Америкийн судлаач МакМанус Жон зах зээлийн ХМХ нь санаачлагатай арга барилаар мэдээлэл олох хийгээд санаачлагагүй арга барилаар мэдээлэл олохын алийг нь илүү ашиглаж байгааг судалж үзээд, сэтгүүлчийн судлах болон мэдээлэх үед зарцуулсан чармайлтын түвшингээр, мэдээлэл олох арга барилыг идэвхжилийн хэмжээгээр нь дээд, доод, дунд гэж гурав хуваасан байдаг.

Идэвхжлийн хэмжээ доод нь эх сурвалж олоход гол төлөв төр засгийн мэдээлэл, мэдээлэгчийн утас, бусад сонин мэдээний байгууллага, нэгжээс авсан материал болон цагдаагийн товчоо, яаралтай хэрэг явдлыг шийдвэрлэх газар зэрэг ордог. Идэвхжилийн хэмжээ дунд нь эх сурвалж олоход гол төлөв хэвлэлийн бага хурал, утсаар авсан албан бус мэдээ, өмнө нь мэдээлж өнгөрсөн хуучин мэдээ юм байна. Идэвхжилийн хэмжээ дээд нь эх сурвалж цуглуулахад гол төлөв ярилцлага хийх, сэдэвтэй холбоотой хуралд оролцох, төр засаг хийгээд хувь хүний бичиг материалыг унших, эрэн сурвалжлах аргаар үнэн зөв бодит хэргийг олох, төр засаг, бизнесийн ёс бус, хууль бус ажиллагааг илчлэх явдал юм. Дээрх гурван мэдээлэл олох арга барилын хүнд хөнгөний хэмжээ нь дарааллан үүссэн байна. Эрдэмтэн МакМанус Жоны судалгаанаас үзэхэд мэдээлэл боловсруулах явцад идэвхжилийн түвшин дээд, өөрийн өртөг хамгийн их эрэн сурвалжлах мэдээллийг хэрэглэж байх нь хамгийн цөөн гэсэн дүгнэлт гаргасан байна. Энэ бол эх сурвалжаас мэдээлэл цуглуулах ажлын хүнд байдал нь түүний практикийн ажиллагаа өрнүүлэх хурдыг удаашруулж, эрэн сурвалжлах сэтгүүл-

чийн тоог нэмэгдүүлэхэд саад болдог. Иймээс ХМ-ийн байгууллагаас идэвхжилийн хэмжээ дээд арга барил дахь хөрөнгө оруулалтаа чухалчлахын хамт сэтгүүлчийн энэхүү ажиллагааг дэмжиж зоригжуулбал сая эрэн сурвалжлах ажиллагаа явуулах санхүүгийн баталгааг хангаж чадна. Өнөөгийн Монгол Улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйд идэвхжилийн хэмжээ доод арга барилыг түлхүү ашиглаж байгаа нь ажиглагддаг.

Гуравт, эрэн сурвалжлах мэдээлийн эрсдэлийн хэмжээ бусад төрлийн мэдээллээс маш их байна. Эрсдэлийн өөрийн өртөг (risk-cost) хэмээх нэр томъёо нь практикт адил бусаар томёологдож, ердөө эрсдэл ажиллагаанаас болсон хохирол болон эрсдэл үүсэхийг хориглохоор авсан арга барилд зарцуулсан зардлыг хэлдэг байна. Үүнийг “нэг зүйлийн ажиллагааг сонгоход зориулах зардлын хэмжээ” гэж ойлгож болно. Эрэн сурвалжлах ажлын эрсдэл их байх нь мэдээжийн хэрэг. Нэг талаар, эрсдлийн хэмжээг эрэн сурвалжлах мэдээллийг сурвалжлан бэлтгэх явцад сэтгүүлчийн хувийн аюулгүй байдлын эрсдэл, ажлын ёс зүйн хийгээд хуулийн эрсдэл зэргээс харж болно. Учир нь эрэн сурвалжлах мэдээллийн сэдэв нь хэзээд хүнд чухал бөгөөд мэдрэмтгий чанар их, эрэн сурвалжлах сэтгүүлч энгийн бус, гэмт хэргийн шинжтэй сэдвийг сурвалжлах арга барил, далдуур сурвалжлахыг хэрэглэдэг. Энэ нь эрэн сурвалжлах ажлын эрсдэл үүсгэхэд хүргэдэг, үүний хамт сэтгүүлчид ажлын ёс зүйн баримтлал болон хувь хүний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлнэ. Нөгөө талаар, эрсдэлийн хэмжээг мэдээллийг дамжуулах явцад тохиолддог “хориотой” эрсдэл болон мэдээлсний дараа “шийтгэх”

эрсдэлээс бас харж болно. Эрэн сурвалжлах нийтлэлийн эх бичвэр нь бэлэн болсон ч нийтлэхийг хориглох, эсвэл ямар нэг мэдээллийг сонгож, сурвалжлах ажиллагаа эхэлмэгц хориотой болох, хамаарал бүхий удирдлагаас хариуцлага нэхэмжилдэг. Дээрх үр дүнг бий болгосон шалтгаан олон байдаг. Үүнд төр засгийн зүгээс хөндлөнгөөс оролцох, эрхийн зөрчил, зах зээл хийгээд хөрөнгө хүчний дутагдал зэргийг нэрлэж болно. ХМ-ийн байгууллагуудад эрэн сурвалжлах шинжтэй материалыг олон төрлийн шалтгаанаас болж нийтэлж, нэвтрүүлж чадаагүй жишээ цөөнгүй байна.

Дээр дурдсанчлан Монгол Улсын ХМХ-ийн эко системийн өнөөгийн байдлаас харвал эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах ажлын гурван “тулгын чулуу”-ны дотор тулгамдсан асуудал нь эрэн сурвалжлах мэдээлэл боловсруулах ажилд багагүй бэрхшээл бий болгожээ. Хэдийгээр дээр дурдсан хэдэн зүйл Монгол Улсын бүхий л сэтгүүл зүйн мэдээллийн хүрээнд, тэр дундаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйд хамгийн илэрхий оршиж, хамгийн ил тод асуудал нь болж байна. Монголын эрэн сурвалжлах мэдээллийн боловсруулах ажилд олон төрлийн тулгамдсан асуудал байх боловч өнөөгийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжил дэх “тулгын гурван чулуу”-г шинжлэх ухаанчаар ашиглавал Монгол Улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь зөв замаар явж байгаа нь ажиглагддаг.

Ишлэл

1. Болормаа Х. “Болор үзэг” сэтгүүл зүй цуврал -1. УБ. 2018. х. 33.
2. Оюун. Мэдээлэл зүй. ӨМИС-ийн хэвлэлийн хороо. 2006. х. 132.
3. Зулькафиль М., Өнөрсайхан Т. Сэтгүүлчийн мэргэжлийн логик зөрчил

ба бэрхшээлүүд. ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл . 2015, № 6.

4. 李良荣. 当代西方新闻媒体 [M], 上海. 复旦大学出版社, 2003, 132页.
5. McManus John H. 张磊译, 市场新闻业-公民自行小心? [M] 北京, 新华出版社, 2004, 13页.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болормаа Л. “Болор үзэг” сэтгүүл зүй цуврал -1. УБ. 2018. х. 33.
2. Зулькафиль М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй: онол, практик, арга зүй. УБ. 2003.
3. Зулькафиль М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ. 2015.
4. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ. 2005.
5. Зулькафиль М., Өнөрсайхан Т. Сэтгүүлчийн мэргэжлийн логик зөрчил ба бэрхшээлүүд. ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл . 2015, № 6.

6. McManus John H. 张磊译, 市场新闻业-公民自行小心? [M] 北京, 新华出版社, 2004, 13页.
7. Оюун. Мэдээлэл зүй. ӨМИС-ийн хэвлэлийн хороо. 2006. х. 132.
8. 李良荣. 当代西方新闻媒体, 上海. 复旦大学出版社, 2003.

Резюме

В статье автор опираясь на выводы и рекомендации монгольских и зарубежных исследователей журналистики и практические материалы СМИ анализирует особенности развития современной монгольской расследовательской журналистики и показывает её удаchi и недостатки. Также автор предлагает некоторые рекомендации, направленные на решение актуальных проблем расследовательской журналистики и улучшение качества её публикаций и передач.